



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/10

Алтай хот

Тээврийн хэрэгслийн техникийн
хяналтын улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолоор баталсан Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж оношлогооны төлбөрийн хэмжээ, Зам тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 232 дугаар тушаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, бүх төрлийн тээврийн хэрэгслийн 2022 оны татвар төвлөрүүлэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд тус тус зохион явуулсугай.

2.Техникийн хяналтын үзлэг явуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт явуулах тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хугацааг гуравдугаар, сумдад ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Үзлэгийн хуваарь, бэлтгэл ажлын талаар тээврийн хэрэгсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хэвлэл, радио, телевиз болон албан бичгээр урьдчилан мэдээлэл өгч ажиллахыг Автотээврийн төв (С.Гантулга), аймгийн Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Албан журмын даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны аймаг дахь салбар (Н.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2.

5.Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, татварын улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багийн Засаг дарга нарыг комиссын бүрэлдэхүүнд ажиллуулан, хавсралтад дурдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт бэлэн байлгах, ажлын явцын мэдээ тайланг холбогдох байгууллагуудад сар тутам мэдээлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтоосон хувь хэмжээний дагуу хугацаанд нь хурааж төвлөрүүлэх ажлыг аймгийн Татварын хэлтэс (Н.Энхтуяа)-т үүрэг болгосугай.

7.2021 оны Техникийн хяналтын үзлэгт хугацаандаа хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтын дагуу тус тус арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 17-ны өдрийн #110 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ КОМИССЫН АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг: Техникийн хяналтын үзлэгийн зорилго:

1. Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандартыг хангуулах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга дэг журам, соёлыг дээшлүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Хоёр: Хяналтын үзлэг хийх бүрэлдэхүүнд орох байгууллагууд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Автотээврийн төв, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс хамтран хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.

Гурав: Техникийн хяналтын үзлэг хийх үе шат, гүйцэтгэх ажил:

1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах;

2. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчлөгч тээврийн хэрэгслийг бүртгэлийн нэгдсэн цахим сүлжээнд оруулах;

3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын хураамж төлөгдсөн, жолоочийн албан журмын даатгалд хуулийн дагуу хамрагдсан, хяналтын үзлэгийн хураамж төлсөн баримтыг үндэслэн тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт хамруулж, тэнцсэн тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тухайн оны сар өдрийг тэмдэглэн бичилт хийж тэмдэг дарах;

4. Орон нутгийн нийтийн зорчигч тээвэр, нийтийн такси үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллах;

5. Сумуудад ажиллах үед техникийн хяналтын үзлэгт хамрагдах тээврийн хэрэгсэл зогсох зогсоолын зурвас татах, цахилгаан эрчим хүч, ажиллах, амрах байраар хангах, амралтын өдөр банк ажиллуулах;

6. Орон нутагт тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн явц, байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчилах стандартын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан стандартын шаардлага хангуулах, тээврийн хэрэгслээ хяналтын үзлэгт хугацаанд нь хамруулаагүй иргэд, албан байгууллагын удирдлагуудад нь шаардах хуудас, мэдэгдэл өгөх, хариуцлага тооцож ажиллах мөн тухайн сумд техникийн хяналтын үзлэг явуулахад бүртгэлтэй тээврийн хэрэгслийнхээ 75 хувиас доош хамрагдуулсан сумдыг Засаг даргатай нь хариуцлага тооцож давтан үзлэг зарлаж, өөрсдийн зардлаар нь дахин техникийн хяналтын үзлэг явуулна.

7. Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн ажлын дүн мэдээг сум, баг бүрээр тус тусад нь үнэлгээ өгч, 2022 оны нэгдсэн тайлан гаргаж аймгийн Засаг даргад танилцуулах техникийн хяналтын үзлэгийг хангалттай сайн зохион байгуулсан сумын ажлын хэсгийг урамшуулах, хангалтгүй ажилласан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын эрхийн хэмжээнд хариуцлага тооцно.

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 17-ны өдрийн 110 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
ҮЗЛЭГ ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Г.Чинбат -(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Гантулга -(Автотээврийн төвийн дарга)
Н.Эрдэнэ-Очир-(аймгийн Цагдаагийн газрын дарга)
Н.Энхтуяа -(аймгийн Татварын хэлтсийн дарга)
А.Ержан -(аймгийн Цагдаагийн газрын Замын
цагдаагийн тасгийн дарга)
Д.Бат-Эрхэм -(Автотээврийн төвийн хяналтын улсын
байцаагч)
Д.Бат-Ирээдүй -(Авто тээврийн төвийн оношлогч инженер)
А.Хонгорзул -(Татварын хэлтсийн Татвар хураалтын
тасгийн дарга)
Н.Бямбасүрэн -(Албан журмын даатгагчдын холбооны
менежер)
Нарийн бичгийн дарга: З.Жаргалтуяа -(Сумдын Засаг дарга нар)
-(аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дэд бүтэц
хариуцсан мэргэжилтэн)

__оОо__

Аймгийн Засаг даргын 2022 оны
 01... дүгээр сарын 17-ны өдрийн 1110 дугаар
 захирамжийн гуравдугаар хавсралт

ЕСӨНБУЛАГ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ТЭЭВРИЙН
 ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ
 ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Авто машины тоо	Машины улсын дугаарууд	Хамрагдах хугацаа	Үзлэгт орсон эсэх
1	Хувь хүмүүс		Жагсаалтаар	2022.01.23- 2022.03.01	
2	"Аяны зам-Алтай" ХХК	100	Жагсаалтаар		
3	"Тэгш-Алтай" ХХК	5	Жагсаалтаар	2022.03.02- 2022.03.08	
4	"Хишиг-Халиун" ХХК	8	Жагсаалтаар		
5	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	9	Жагсаалтаар		
6	"Мөнх жолоо" ХХК	15	Жагсаалтаар		
7	Батлан хамгаалах туслах нийгэмлэг	2	0020ГАА 1704ГАА		
8	"Ихэс-Алтай" ХХК	4	4093ГАА, 897ГАА 7478ГАА, 8387ГАА		
9	Нэгдсэн эмнэлэг	12	Жагсаалтаар	2022.03.09- 2022.03.15	
10	Малын удмын сан	1	6464ГАА		
11	"Мандал-Алтай" ХХК	1	4148ГАА		
12	"Мандал голомт" ХХК	3	2106ГАУ 2179ГАУ 9086ГАА		
13	"Мөрөн-Алтай" ХХК	1	9229ГАА		
14	"Морьт баян" ХХК	1	3339ГАА		
15	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК	2	2298ГАУ 6574ГАА		
16	"Миний нутаг телевиз" ХХК	1	2060ГАУ		
17	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК	16	Жагсаалтаар		
18	"Тайшир-Гуулин усан цахилгаан станц" ХХК	3	5100ГАА 5102ГАА 8644ГАА		
19	Цагдаагийн газар	21	Жагсаалтаар	2022.03.16- 2022.03.25	
20	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	12	Жагсаалтаар		
21	"Тулга-Алтай" ХХК	8	Жагсаалтаар		
22	Аймгийн Засаг даргын Тамгын газар	10	Жагсаалтаар		
23	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	0002ГАА, 0002ГАУ		
24	Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар	4	1153ГАА, 1692ГАУ 1904ГАУ, 6000ГАУ		

25	"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	19	Жагсаалтаар		
26	Шүүх	1	9988ГАА		
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2	7394ГАА, 9848ГАА		
28	Тагнуулын хэлтэс	2	0067ГАҮ, 3776ГАҮ		
29	Статистикийн хэлтэс	1	5109ГАҮ		
30	Прокурорын газар	1	0088ГАА		
31	Мэргэжлийн хяналтын газар	3	0631ГАА, 6354ГАҮ 8508ГАА		
32	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	9	Жагсаалтаар		
33	Боловсрол шинэлэх ухааны газар	2	5569ГАА, 9347ГАА	2022.03.26- 2022.04.10	
34	Нийгмийн даатгалын хэлтэс	1	1189ГАҮ		
35	Татварын хэлтэс	3	0408ГАА, 6969ГАА 7172ГАА		
36	Төрийн аудитын газар	2	2005ГАА, 346ГАА	2022.04.10	
37	Гаалийн хороо	1	7032ГАА		
38	Нийтийн Номын сан	1	0552ГАА		
39	Шүүхийн шинжилгээний алба	1	1223ГАҮ		
40	Нийгмийн үйлчилгээний халамжийн хэлтэс	3	1009ГАА, 1009ГАҮ 1023ГАА		
41	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	1	0868ГАА		
42	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	4	0525ГАА, 6181ГАА 6923ГАА, 811ГАА		
43	"Ус-Алтай" ХХК	3	4137ГАА, 7967ГАА 8208ГАА		
44	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5	0573ГАА, 493ГАҮ, 5525ГАА 2345ГАҮ		
45	АШУҮИС-ийн салбар сургууль	4	1991ГАА, 5030ГАҮ 5054ГАҮ, 8232ГАА		
46	Эрүүл мэндийн газар	5			
47	"Алтайн хүрд" ХХК	4	1381ГАҮ, 1768ГАҮ 2623ГАҮ, 9629ГАА		
48	ХААН банк		Жагсаалтаар		
49	ХАС банк		Жагсаалтаар		
50	Төрийн банк		Жагсаалтаар		
52	Монгол банк	1	Жагсаалтаар		
53	"Бүрэн дуулга-Алтай" ХХК	2	0004ГАА, 1600ГАА		
54	Бэлчээр ашиглалтын холбоо	1	2248ГАҮ		
55	Улсын бүртгэлийн хэлтэс	1	0109ГАА	2022.04.11- 2022.04.16	
56	"Марал-Алтай" ХХК	1	5150ГАА		
57	"Модон чөлөө" ХХК	1	8496ГАА		
58	Олон нийтийн "Алтай" радио	2	1908ГАҮ, 7215ГАА		

59	"Цэргийн булаг" ХХК	1	503.ГАҮ		
60	Автотээврийн төв	1	1602ГАҮ		
61	АДБ-ийн "Алтай" чуулга	1	4800ГАА		
62	Биеийн тамир, спортын газар	3	0003ГАҮ, 2131ГАҮ 7125ГАА		
63	Сум дундын Ойн анги	2	1689ГАҮ, 1716ГАҮ		
64	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	1	8326ГАА		
65	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	1945ГАҮ		
66	Уламжлалт анагаах ухааны төв	1	1489ГАҮ		
67	Улсын нөөцийн салбар	1	6054ГАҮ		
68	Шуудан үйлчилгээний газар	1	7006ГАА		
69	"Нийтлэг үйлчилгээ" УТҮГ	4	6777ГАА, 7849ГАА 8095ГАА, 8096ГАА		
70	"Дуурсах-Алтай" ХХК	1	1302ГАА		
71	"Мөнхтооройт" ХХК	9	Жагсаалтаар		
72	Нефть хангамжийн бааз	1	5497ГАА		
73	Малын удмын сан	1	6464ГАА		
74	"Залуур-Алтай" ХХК	1	3632ГАА		
75	"Ентүм" ХХК	1	5875ГАА		
76	"Гурван хулд" ХХК	1	2409ГАА		
77	Орон нутгийг судлах музей	1	1583ГАҮ		
78	"Алтай" нисэх буудал	5	8866ГАА, 527УБС		
79	"Атар-Арвай" ХХК	1	9661ГАА		
80	Зоонозын өвчин судлалын төв	2	3168ГАА, 9332ГАА		
81	"Мон-суль" ХХК	4	0333ГАА, 4704УБП 5599ГАА, 5998ГАА	2022.04.16	
82	"Аксу-Алтай" ХХК	1	0322ГАА		
83	"Эрүүл ус" ОНӨААТҮГ	2	2564ГАА, 2666ГАҮ		
84	"Айргийн хад" ХХК	4	Жагсаалтаар		
86	Онцгой байдлын газар		9500ГАА, 1050ГАА 1689ГАА, 1210ГАҮ 1684ГАА, 1690ГАА 0105ГАҮ		
87	Рашаант баг	50	Жагсаалтаар	2021.04.15	

Аймгийн Засаг даргын 2022 оны
 01 дугаар сарын 17-ны өдрийн 1110 дугаар
 захирамжийн дөрөвдүгээр хавсралт

**СУМДЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ
 БҮРЭЛДЭХҮҮН МАРШРУТ, ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУГАЦАА**

1 дүгээр чиглэл

№	Техникийн хяналтын үзлэг явуулах сум багийн нэр	Хугацаа	Хоорондын зай км	Аймгаас ажиллах бүрэлдэхүүн
1	Гуулин тосгон	2022.04.18-18	90	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-1, техникч-1, бүртгэлийн мэргэжилтэн-1
2	Дэлгэр сум	2022.04.19-21	30	
3	Чандмань сум	2022.04.22-04.24	150	
4	Эрдэнэ сум	202.04.25-27	35	
5	Гэгээт баг	2022.04.28	45	
6	Баянтоорой тосгон	2022.04.29	170	
7	Зам хоног	2022.04.30	0	
8	Цогт сум	2022.05.01-03	90	
9	Бигэр сум	2022.05.04-05	87	
10	Наран баг	2021.05.06	75	
11	Алтай хотод ирэх	2021.05.07	35	

2 дугаар чиглэл

1	Олонбулаг баг	2022.05.16	85	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-1, техникч-1, бүртгэлийн мэргэжилтэн-1
2	Халиун сум	2022.05.17-18	50	
3	Цээл сум	2022.05.19-20	85	
4	Дэрстэй баг	2022.05.21	45	
5	Алтай сум	2022.05.22-24	200	
6	Зам хоног	2022.05.25	0	
7	Тахийн тал	2022.05.26	280	
8	Бугат сум	2022.05.27-28	30	
9	Төгрөг сум	2022.05.29-30	60	
10	Алтай хотод ирэх	2022.05.31	146	

3 дугаар чиглэл

1	Шарга сум	2022.06.07-08	85	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-1, техникч-1, бүртгэлийн мэргэжилтэн-1
2	Тонхил сум	2022.06.09-11	125	
3	Дарив	2022.06.12-14	38	
4	Хөх-морьт сум	2022.06.15-16	110	
5	Зам хоног	2022.06.17	0	
6	Баян-Уул сум	2022.06.18-20	78	
7	Жаргалан сум	2022.06.21-22	75	
8	Тайшир сум	2022.06.23-24	78	
9	Алтай хотод ирэх	2022.06.25	45	

4 дүгээр чиглэл

1	Алтайн хүдэр Таян нуурын уурхай	2021.09.12	220	440	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-техникч, бүртгэлийн мэргэжилтэн
---	------------------------------------	------------	-----	-----	--

Тайлбар: Цар тахал (ковид-19)-ын улмаас техникийн хяналтын үзлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэл ариутгал халдваргүйжилт хийж, жолооч нар амны хаалт зүүж машин тээврийн хэрэгслээсээ буухгүй, машин дотроо бөөгнөрөл үүсгэхгүй байхыг анхааруулж байна.